

Таны дүрвэгсдийн процедур эхлэхээс өмнө

Та ямар тохиолдолд энэ товхимолын хүлээж авах вэ?

Та Нидерландын Вант улсад дүрвэгсдийн орогнол асуухыг хүсэж байна. Дүрвэгсдийн процедур таныг Нидерландын Вант улсад ирэнгүүт шууд эхэлдэггүй. Эхлээд танд аян замын алжаалаа тайлах ба Дүрвэгсдийн Ерөнхий Процедуртаа бэлдэх хугацаа олгодог. Танаас мөн хэд хэдэн зүйлийг асуудаг. Танд хамгийн багадаа зургаан хоногийн хугацаа өгдөг. Энэ хугацааг амрах болон бэлтгэлийн хугацаа(RVT) гэж нэрлэдэг.

Энэ товхимолоос та дүрвэгсдийн процедурын өмнө ямар үйл ажиллагаа явагдахыг дэс дарааллан унших болно.

1 дүгээр алхам: ирснээ мэдэгдэх ба бүртгүүлэх

Та Тэр-Апэл хотын бүртгэлийн төвд ирснээ мэдэгдэнэ. Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлийг Хариуцсан Байгууллага (IND)- гийн ажилтнууд таны хувийн мэдээллийг тэмдэглэж авна. Та асуултын хүснэгтийг цаасан дээр эсвэл компьютер дээр бөглөнө. Дараа нь та Тэр-Апэл хот дахь юмуу эсвэл өөр газрын Гадаад Иргэдийн Цагдаагийн Алба АВИМ (AVIM) уруу явна.



Гадаад Иргэдийн Цагдаагийн алба (AVIM) – нь Нидерландын Вант улсын цагдаагийн албаны харьяа бөгөөд Нидерландын Вант улсад байгаа гадаадын иргэдийг хянах үүрэгтэй байдаг.

Гадаад Иргэдийн Цагдаагийн Албаны ажилтнууд таны хувийн мэдээллийг; овог нэр, төрсөн он сар ба иргэншил гэх мэтийг бүртгэдэг. Тэд мөн таны хувцас ба ачаа тээшийг шалгаж, зураг болон хурууны хээг тань авдаг. Таны хурууны хээг авах болсон шалтгааны талаар танд товхимол өгсөн байгаа.

Таны туулсан аян замын тухай, урьд өмнө нь та эндээс болон өөр бусад Европын орнуудаас орогнол асууж байсан эсэх, энд болон өөр бусад Европын орнуудад таны төрөл садангууд амьдардаг эсэхийг танаас мөн асуух болно.

Танд өөрийгөө хэн болохыг нотлох бичиг баримт, паспорт, иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ юмуу жолооны үнэмлэх байна уу?

Эсвэл танд туулсан аян замын болон дүрвэх болсон түүхийг нотолсон бичиг баримтууд жишээ нь онгоцны билет, тийз, дипломууд, шүүхийн шийдвэр ба сонингийн нийтлэл байна уу? Энэ бичиг баримтуудаа бүртгүүлэх үедээ өгөх юмуу эсвэл дүрвэгсдийн процедураа эхлэхээс өмнө олж бүрдүүлнэ үү. VluchtelingenWerk- (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтан таны энэ ажилд тусалж чадна.



VluchtelingenWerk Nederland – Нидерландын ДүрвэгсдийнАжил бол биеэ даасан хүний эрхийг хамгаалах байгууллага бөгөөд дүрвэгсдийн эрх ашгийг хамгаалахын тулд байгуулагдсан юм. VluchtelingenWerk ДүрвэгсдийнАжил танд болон дүрвэгсдийн процедурын тухай тайлбар ба мэдээлэл өгдөг. Таныг процедураа туулахад, хувийн мэдээллийг тань лавлаж өгөх ба өөр байгуулгуудтай үүссэн асуудлуудыг тань зохицуулж өгөхөд VluchtelingenWerk тусалдаг. Тэд энэ үйл ажиллагаандаа таны өмгөөлөгчтэй хамтран ажилладаг. VluchtelingenWerk таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд шийдвэр гаргахгүй.

Таны бичиг баримтуудын жинхэнэ эсэхийг мэргэжилтэнүүд шалгадаг. Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлийг Хариуцсан Байгууллага (IND) таны дүрвэгсдийн асуудлыг дүгнэж шийдэхдээ энэ бичиг баримтуудыг ашигладаг.

Таны хувийн мэдээлэл ба таны бичиг баримтууд дүрвэгсдийн процедурын асуудлыг шийдэхэд чухал нөлөө үзүүлдэг. Өгч буй мэдээлэл тань бүрэн гүйцэд мөн зөв бичигдсэн эсэхийг шалга. Хувийн бичиг баримтаа хэзээ ч битгий хая. Нидерландын Вант улс таны эх орны засаг захиргаанд таныг Нидерландын Вант улсад дүрвэгсдийн орогнол асуусан гэж хэзээ ч дамжуулахгүй.

2 дахь алхам: Сүрьеэ өвчний үзлэг

Сүрьеэ (ТВС) бол маш аюултай, дэлхийд ихээр тархсан өвчин юм. Магадгүй таны амьдарч байсан оронд ч байж болзошгүй. Онгорхой сүрьеэтэй хүмүүс өөр бусад хүмүүст жишээ нь хайнааж, найтаах замаар халдвар түгээх аюултай. Тиймээс таныг Тэр-Апэл – д бүртгүүлэх үеэр энэ өвчний шинжилгээг авна. Ихэнхдээ сүрьеэ өвчин нь уушгинд оршиж халдварладаг. Тиймээс өвчнийг оншлохдоо уушигны зургийг авдаг. Хэрвээ та сүрьеэтэй бол таныг Нидерландын Вант улсад эм өгч эмчилдэг. Энэ тохиолдолд дүрвэгсдийн процедур эмчилгээний дараа эхэлнэ.

3 дахь алхам: Бүртгэлийн ярилцлага

Бүртгэлийн ярилцлагын үеэр IND-гийн ажилтан голдуу таныг хэн болох мөн таны иргэншил харьяаллын тухай асуултууд тавьдаг. Хэрвээ та зарим тодорхой заасан улсын нутгаас ирсэн тохиолдолд заримдаа танаас нэмэлт асуултууд асуудаг. Энэ ярилцлаганд таны Нидерландын Вант Улсаас уруу ирж дүрвэх болсон шалтгааны тухай асуултууд асуухгүй.



Immigratie- en Naturalisatiedienst
Ministerie van Veiligheid en Justitie

Immigratie- en Naturalisatiedienst (IND) – Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага (ИНД) нь Нидерландын Вант улсын Хууль Зүй ба Батлан Хамгаалах Яамны харьяа байгууллага юм. IND-гийн ажилчид таныг хэн болох, таны иргэншил харьяалал, ирэхдээ туулсан зам, эх орноосоо дүрвэн гарсан шалтгааны тухай таньтай ярилцдаг. Тэгээд тэд таны хувийн түүхийг болон эх орны тань нөхцөл байдлыг судалдаг. Дараа нь тэд таныг Нидерландын Вант улсад (түр хугацаанд) үлдэж болох эсвэл эх орондоо буцах ёстой эсэхийг шийдвэрлэдэг.

4 дүгээр алхам: байр

Гадаад Иргэдийн Цагдаагийн Албанд бүртгүүлснийхээ дараа танд Нидерландын Вант Улсын засгийн газраас орогнох байр, хоол хүнс ба эрүүл мэндийн тусламжийг олгодог. Тэр-Апэл – ийн Гадаад Иргэдийн Цагдаагийн Албаны байранд Centraal Orgaan orvang asielzoekers (COA) – Дүрвэгсдийг Хүлээн Авах Төв Байгууллагын байр байгаа. Та тэнд хоноглох болно.

Таны ирснээ бүртгүүлсний дараа болон IND – д өгсөн бүртгэлийн ярилцлагын дараа таныг Дүрвэгсдийг Хүлээн Авах Төв Байгууллага (COA)-ын өөр байранд аваачна.

Энэ дүрвэгсдийн төв нь таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг шийдвэрлэж байгаа Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллагын кантоортой ойрхон байдаг.



COA Centraal Orgaan opvang asielzoekers

Centraal Orgaan opvang asielzoekers (COA)

– Дүрвэгсдийг Хүлээн Авах Төв Байгууллага (COA) нь Нидерландын Вант улс дахь дүрвэгсдийг хүлээн авах ба үүнтэй холбоотой асуудлуудыг хариуцдаг. COA таныг хоол, байраар хангах ба эрүүл мэндийн зардлын даатгалтай болоход тусалдаг. Та эмчтэй холбогдож тусламж авахаар бол COA-д хандаж болно. COA бол биеэ даасан байгууллага ба таны дүрвэгчийн асуудлыг шийдэхгүй.

COA-гийн дүрвэгсдийн төв байранд байх хугацаандаа та эрүүл мэндийн танилцах ярилцлагын урилга хүлээн авна. Энэ ярилцлаганд таны эрүүл мэнд болон өвчин эмгэгийн асуудлыг хэлэлцдэг. Ингэснээрээ тэд таныг COA-гийн дүрвэгсдийн төвд байрлах үед зөв эрүүл мэндийн тусламж үзүүлж чадна.



GezondheidsZorg Asielzoekers (GZA) –

Дүрвэгсдийн Эрүүл Мэндийн (GZA) байгууллагад та өвдсөн үедээ болон эрүүл мэндтэйгээ холбогдолтой асуултынхаа талаар хандаж болно. COA-гийн байр болгоны ойролцоо GZA-ийн төв байрладаг. GZA нь танд эмчийн туслахтай, сувилагч нартай, GGZ-ийн эмчилгээний туслахуудтай болон өрхийн эмчтэйгээ цаг авч уулзахад танд тусалдаг. Та өдөр шөнийн аль ч цагт эрүүл мэндийн холбоо барих төвд “Дадлагын дугаар”: 088 112 21 12-луу залгаж асуултуудаа тавьж болно. Энэ дугаарлуу та Даваа гаригаас Баасан гариг хүртэл өвчнөөс бусад өөр асуултуудыни талаар залгаж ярьж болно. Жишээ нь та нарийн мэргэжлийн эмчид хандахад шаардлагатай бичиг, захиа авахыг хүсч байгаа бол бас залгаж болно.

5 дахь алхам: мэдээлэл

Та COA-гийн дүрвэгсдийн байранд Нидерландын Вант улсад ирсэн аян замын алжаалаа тайлна. Та тэгээд Дүрвэгсдийн Ерөнхий Процедургаа бэлдэнэ. Зарим тохиолдолд амрах болон бэлтгэлийн хугацаа (RVT) хүчингүй болох эсвэл зогсож та шууд Дүрвэгсдийн Ерөнхий процедурт шилжинэ. COA-гийн байранд танд VluchtelingenWerk (ДүрвэгсдийнАжил)– байгууллага дүрвэгсдийн процедурын тухай болон эрүүл мэндийн талаар зөвлөгөө өгдөг. Ярилцлагын үеэр хэлмэрч байж таны болон VluchtelingenWerk– (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтны хэлсэн болгоныг орчуулж өгнө. Түүнчлэн та энэ дүрвэгсдийн процедурын тухай товхимол хүлээн авна. VluchtelingenWerk– (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтан мэдээлэл өгөх ба таны дүрвэгсдийн процедурын үеэр танд тусалдаг. VluchtelingenWerk– (ДүрвэгсдийнАжил) байгууллагын үйлчилгээ үнэгүй байдаг.

Тэд таны мэдээллийн нууцыг чандлан хадгалж ажилладаг.

6 дахь алхам: эрүүл мэндийн зөвлөгөө



FMMU

FMMU - Дүрвэгсдийн төвд танд Forensisch Medische Maatschappij Utrecht – Шүүх Эмнэлгийн Эрүүл мэндийн Эмгэг судлалын Утрэхтийн Төвийн сувилагчтай уулзах цаг өгнө. Энэ сувилагч танаас эрүүл мэндийн үзлэгт орох уу гэж асууна. Энэ үзлэгийн зорилго нь танд сэтгэл мэдрэлийн ба/ эсвэл бие махбодийн ямарваа өвчин эмгэг буй эсэх, энэ эмгэг нь таны IND-д өгөх ярилцлагуудад нөлөө үзүүлэх эсэхийг судална.

Энэ үзлэгт эмнэлгийн ажилтан танаас асуултууд асууна. Энэ ярилцлагад хэлмэрч тусалж таны болон сувилагчийн хэлсэн болгоныг орчуулж өгнө. Ихэнхдээ хэлмэрч биечлэн ирэхгүйгээр утсаар орчуулж өгдөг. Хэрвээ шаардлагатай гэж сувилагч үзвэл таныг нарийн мэргэжлийн үзлэгт оруулахаар эмч рүү явуулдаг. Гарсан шинжилгээний хариуг сувилагч юмуу эмч зөвхөн таныг хүссэн тохиолдолд л IND-рүү илгээдэг. IND таны дүрвэгсдийн процедурын үеэр таны эрүүл мэндийн асуудлыг харгалзан үздэг.

Та сэтгэл мэдрэлийн ба биеийн зовиураа шударгаар сувилагчид юмуу эмчид ярих нь их чухал юм. Хэрвээ танд шарх сорви байгаа бол үүнийгээ сувилагчид мэдэгдэх нь чухал юм. Эрүүл мэндийн шинжилгээний хариу бол хувийн нууц. Эрүүл мэндийн шинжилгээг хүн бүр өгөх албагүй. Та эрүүл мэндийн шинжилгээнд мөнгө төлөхгүй.

Хэрвээ та Эрүүл мэндийн шинжилгээ өгөх хүсэлгүй бол сувилагчид мэдэгдээрэй. Энэ тохиолдолд IND таны дүрвэгсдийн процедурын үеэр таны эрүүл мэндийн асуудлыг харгалзан үзэж чадахгүй. Энэ эрүүл мэндийн зөвлөгөө нь COA-гийн дүрвэгсдийн байранд авч болох эрүүл мэндийн тусламжаас өөр юм.

7 дахь алхам: өмгөөлөгчийн тусламж

Та дүрвэгсдийн процедурын үеэр өмгөөлөгчийн тусламж авна. Энэ өмгөөлөгч нь Нидерландын Вант улсын засгийн газарт хамааралгүй биеэ даасан хүн байдаг.

Raad voor Rechtsbijstand *legal aid*

Raad voor Rechtsbijstand (Legal Aid)- Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар таныг өмгөөлөгчийн тусламж аваад зардлыг нь төлж чадахгүй тохиолдолд тусалдаг. Өмгөөлөгчийн танд үзүүлсэн үйлчилгээний хөлсийг Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар өмгөөлөгчид төлдөг. Өмгөөлөгч бол Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газрын ажилтан биш юм. Өмгөөлөгч бол таны дүрвэгсдийн процедурт тусалцаа үзүүлэх биеэ даасан хууль эрх зүйн тусламж үзүүлэгч юм.

Ta Raad voor Rechtsbijstand - Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газраар дамжуулан өмгөөлөгчтэй уулзах урилга хүлээн авна. Та өмгөөлөгч хайх хэрэггүй. Дүрвэгсдийн процедурын хугацаа маш бага байдаг тул Raad voor Rechtsbijstand - Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар танд цагт нь амжиж өмгөөлөгч олж өгдөг. Хэрвээ та аль хэдийн өмгөөлөгчтэй уулзсан бол үүнийгээ бүртгэлийн ярилцлагандаа мэдэгдээрэй.

Өдөр бүр та шуудангаа шалгана уу. Өмгөөлөгчтэйгөө уулзах анхны уулзалт бол таны дүрвэгсдийн процедурт маш чухал тул та заавал очиж уулзаарай. Энэ уулзалтанд өмгөөлөгч таныг IND - д өгөх ярилцлагуудад бэлддэг. Энэ өмгөөлөгчийн бэлтгэх ярилцлага нь өмгөөлөгчийн кантоорт болдог. Өмгөөлөгчийн кантоор уруу явах замын маршрут, галт тэрэг ба автобусанд үнэгүй зорчих билетийг танд өгдөг. Энэ ярилцлагад хэлмэрч тусалж таны болон өмгөөлөгчийн хэлсэн болгоныг орчуулж өгнө. Өмгөөлөгчийн тусламжинд та мөнгө төлөх шаардлагагүй. Таны мэдээллийн нууцыг тэд чандлан хадгалж ажилладаг.

Дүрвэгсдийн процедур

Таныг Гадаад Иргэдийн Цагдаагийн алба – нд ирснээ мэдэгдсэний дараа хамгийн багадаа зургаан хоногийн дараа та IND-д анхныхаа ярилцлагыг өгдөг. Амьдрал дээр үүнээс ч илүү удаж байж ярилцлагадаа орох тохиолдол байдаг. Таны анхны ярилцлагад орох урилга COA-гийн дүрвэгсдийн байранд ирдэг. Дүрвэгсдийн процедурын талаар илүү мэдээллийг хэдхэн хоногийн дотор VluchtelingenWerk (ДүрвэгсдийнАжил)– байгууллагаас аваарай (5 дахь алхмыг унш).

Гаргасан өргөдлөө буцаан татах

Та гаргасан өргөдлөө хүссэн үедээ буцааж авч болно. Энэ тохиолдолд таныг өмгөөлөгчтэйгөө уулзахыг зөвлөдөг боловч шууд IND-д хандаж ч бас болдог. Хэрвээ та IND-гээс өргөдлөө буцаан авбал танд энэ улсад өөр шалтгаанаар оршин суух эрх байхгүй л бол Нидерландын Вант улсад байж болохгүй болдог.

Хувь хүний мэдээллийн боловсруулалт

Хувь хүний мэдээлэл бол таны талаарх бүх төрлийн мэдээлэл юм. Энэ товхимолын доор бидэнтэй хамтран ажиллаж буй байгууллагуудын нэрсүүд байгаа. Эдгээр байгууллагууд таны дүрвэгсдийн өргөдөл, мэдэгдэл эсвэл хүсэлтийг боловсруулах явцдаа таны хувийн мэдээллийг ашигладаг. Танаас тэд таны мэдээллийг асуугаад хэрвээ шаардлагатай бол бусад байгууллагууд, хүмүүсээс таны талаархи мэдээллийн талаар лавладаг. Эдгээр байгууллагууд таны өгөгдлийг ашиглаад, хадгалж, хуулийн дагуу шаардлагатай бол бусад байгууллагуудад мэдээллийг дамжуулдаг. Хувь хүний нууцлалын тухай хууль тогтоомжинд таны өгөгдлийг боловсруулдаг байгууллагуудын дагах ёстой үүргүүдийг заасан байдаг. Жишээлбэл, тэд таны өгөгдлийг анхааралтай, аюулгүйгээр боловсруулах ёстой. Хувь хүний нууцлалын тухай хуулинд мөн таны эрхийн талаар заасан байдаг, тухайлбал:

- Байгууллагуудаас өөрийн мэдээллийн талаар асууж мэдэх;
- Байгууллагууд таны өгөгдлөөр юу хийдэг, яагаад таны өгөгдлийг хуримтлуулж байгаа гэдгийг мэдэх;
- Цаашлаад ямар байгууллагуудад таны мэдээллийг дамжуулж өгч байгааг мэдэх эрхтэй.

Та өөрийн хувийн мэдээллийн боловсруулалт болон өөрийн эрхийн талаар илүү ихийг мэдэхийг хүсч байна уу? Тэгвэл тухайн байгууллагуудын вэбсайтуудыг судлана уу. Энэ товхимолын доод хэсэгт та тэдгээр байгууллагуудын вэб хаягуудыг олж болно.

Ихэвчлэн тавигддаг асуултууд

Энэ мэдээллийн хуудсыг уншсаны дараа танд асуух зүйл байна уу?

Асуулт байгаа бол өөрийнхөө өмгөөлөгч, COA-гийн юмуу, VluchtelingenWerk- (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтангуудын нэгтэй нь уулзана уу.

Та гомдолтой байна уу?

Бүх дүрвэгсдийн процедуртай холбоотой ажилладаг байгуулгууд мэргэжлийн түвшинд, хянамгай ажилладаг. Хэрвээ та үнэхээр ямар нэгэн байгууллага танд муугаар хандсан гэж үзэж байгаа бол, гомдол мэдүүлж болно. Таны өмгөөлөгч юмуу VluchtelingenWerk- (Дүрвэгсдийн ажил) байгууллагын ажилтан танд туслах болно.

Энэ нийтлэлийг хамтран гаргасан:

Дүрвэгсдийг Хүлээн Авдаг Төв Байгууллага (COA) | www.coa.nl

Эх оронд нь буцаах болон буцах байгууллага (DT&V) | www.dienstterugkeerenvertrek.nl

Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага (IND) | www.ind.nl

Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар | www.rvr.org
Нидерландын ДүрвэгсдийнАжил байгууллага | www.vluchtelingenwerk.nl

Даалгавраар бичигдэв.

Хууль Зүй ба Батлан Хамгаалах Яам, Дүрвэгсдийн асуудал хариуцсан захиргааны www.rijksoverheid.nl

Энэ нийтлэлийн агуулгад зохиогчийн эрхийг түгээх боломжгүй. Хэрвээ орчуулгад утга санааны зөрөө гарвал Нидерланд хэл дээрхи нийтлэлийг дагана.